

Эртний еврейн шашныг судлах эх сурвалжууд

О. Чимэг - МУИС, Шашин судлалын тэнхмийн багш, доктор

Түлхүүр үг: иудаизм, Библи, Хуучин Гэрээ, Моисей, Тора, Талмуд, Яхве - гийн хууль.

Товч утга: Еврейчүүдийн шашин иудаизм нь дэлхийн хоёр том шашин болох христос ба ислам шашны үзэл санаа бүрэлдэхэд асар их нөлөө үзүүлсэн ба еврейчүүдийн ариун судар Библи / Хуучин Гэрээ / -ийг христос шашинтнууд мөн л ариун судрын хувьд дээдлэн шүтдэг. Дэлхий ертөнцийг үүтгэгч нэг Эзэн тэнгэрийн үзэл санаа бүхий эртний еврейчүүдийн шашныг судлах гол сурвалжуудын талаар энэ өгүүлэлд авч үзсэн болно.

Еврейчүүдийн шашин иудаизм нь өнөөг хүртэл бараг өөрчлөлтгүй хадгалагдаж ирсэн эртний ертөнцийн цөөн тооны үндэстний шашны нэг. Иудаизм нь ерөөс шашны түүхэнд ихээхэн үүрэг гүйцэтгэсэжээ. Орчин үеийн дэлхийн хоёр том шашин болох христос ба исламын шашны үзэл санаа бүрэлдэхэд чухал нөлөө үзүүлсэн. Тиймээс ч энэ шашныг олон орны судлаачид сонирхож судалж ирсэн байна / 6 /. Манай оронд энэ шашны талаар ойлголт өгөхүйц анхны бүтээлүүдийн нэг нь зөвлөлт оросын судлаач С. А. Токаревийн бүтээл / "Религия в истории народов мира" / болов уу. 90-ээд оноос хойш христос шашныг сурталчлагчид олноороо орж ирж, Монголын хүн ам дотор христос шашныг шүтэгчид бий болсон ба Библи монгол хэлэнд орчуулагдсанаар еврейн шашинтан ба христос шашинтны аль алины шүтдэг Хуучин Гэрээ, түүний үзэл санааг мэдэх, гадарлах хүмүүс бий болсон. Зарим телевизээр христос шашныг сурталчлах зорилгоор Хуучин Гэрээнээс сэдэвлэсэн кинонууд гарч байгаатай тааралдсан нэг нь өөр өөрийнхөөрөө дүгнэдэг биз. Үзсэн нь Хуучин Гэрээний "гол сэдвийн нэг болох еврейчүүдийн домогт өвөг дээдсийн түүх, ертөнцийг үзэх үзэлтэй танилцах боломжтой юм. Гэвч еврейн шашин бүү хэл христос шашны уламжлал үгүй байсан манай орны хувьд иудаизмийн талаар төсөөлөл муутай явж ирсэн. Сүүлийн жилүүдэд шинээр орж ирсэн христос шашны учрыг олох эрмэлзэл, нөгөө талаар гадаад харилцаа, түүний дотор "олон улсын мэдээний" байнгын сэдэв болдог Ойрхи Дорнод, түүний дотор Израиль улстай харилцах харилцаа өргөжихийн хэрээр еврейн шашин нэлээд сонирхогдох болсон. Энэ удаа еврейн шашныг судлах сурвалжуудын тухай С.А.Токаревийн бүтээл, судалгааны бусад ном зохиол, гарын авлага ба Библид тулгуурлан уншиж мэдсэн хэмжээндээ өгүүлэхийг зорьлоо.

Еврейн шашин ба Библи. Еврейн шашин иудаизм нь м.э.ө. II мянган жилд Хойд Аравиар нүүдэллэн аж төрж байсан еврей омгуудын политеист шүтлэг, зан үйлийн үндсэн дээр бүрэлджээ. / 1 / Еврейчүүдийн шашин иудаизмийн нэр Иудайгийн омгийн тэнгэр Яхве-гийн шүтлэгтэй холбоотой ба дуудлага нь орос хэлнээс орж ирсэн, англиар бол Иуда нь Judah / 7 / буюу Жүда. Жүда нь еврей хэлний дуудлагад илүү ойр байж болохын зэрэгцээ монгол хэлэнд Библи нь англи хэлнээс орчуулагдсан учир хүний нэрсийн дуудлага нь англи хэлнийхэд илүү ойр байдаг. Гэвч анх мэдэж авсан орос дуудлагыг баримтлан, холбогдох газар хаалтанд англи бичлэгийг /6,2 / хавсаргахыг хичээн өгүүлъя.

Иудаизмийг еврейчүүдийн домогт хууль тогтоогч Моисейн / Моше, англиар Moses / нэрээр Моисейн шашин, Моисейн хууль гэж нэрлэдэг /англичүүд "мозаизм" гэдэг / 6 /. Моисей нь Библийн домогт дүр бөгөөд иудейн болон христос шашинд Яхве тэнгэрийн лүндэн буулгагч, шашных нь үндэслэгч гэж үздэг. Тэрээр Египетэд төрсөн нь тэр үед еврейчүүд Египетэд нутаглаж

байсантай холбоотой байв. Моисей нь фараоны ордонд хүмүүжиж том болоод сайн дураараа цөлөөр хэрэн тэнүүчилж, ингэж явахдаа Израиль хүн гэдгээ ухамсарласан бололтой. Түүний овгийн тэргүүн нь еврейчүүдийн домогт дээд өвөг Авраамын / Abraham, Abram / жич хүү, Иаковын / Jacob / хүү Левий байв.

80 настай байхдаа ариун гэж тооцогддог Синайн хойгийн Хорив уулын хормойд хонь хариулж явахад нь бургас шатаж, Эзэн тэнгэр Яхве чанга дуугаар "Би эцгийн чинь эзэн тэнгэр, Авраам. Исаак, Иаковын эзэн тэнгэр байна" хэмээн өөрийгөө мэдүүлж Египетээс өөрийнхөө ард түмнийг дагуулан гаргахыг тушааж байна" хэмээжээ / 2 /

Библид үздэгээр Моисей Яхве-гийн тусламжтайгаар фараонд боолчлогдож байсан еврейчүүдийг Ханаан нутаг руу дагуулж аваачсан. Энэ үйл явдал "Орхин одсон нь" хэмээх Моисейн таван номны хоёрдоход гардаг / 6,7 /

Египетээс Палестин руу аялах замд Синай уулан дээр Яхве түүнд арван зарлиг /хууль, сургаал / бүхий чулуун хавтан өгсөн нь декалог буюу арван сургаал хэмээн нэрлэгддэг. Моисейг еврейн шашны хууль тогтоогч хэмээн үздэг ба Таван ном буюу Тора - г түүнийх гэдэг. Тора гэдэг нь хууль ёсны, сургаалын ном гэсэн утгатай өгүүлэн буй таван номын эртний еврей нэр ба зан үйл явуулахад зөвхөн гараар пергаментад бичсэн судар хэрэглэх ажээ. / 1 /

Еврейчүүдийн анхны хаан нь венианимит омгийн Саул байсан бол дараагийн угсаа залгамжилсан хаад Давид, Соломон нар Иудагийн омгийнх байсан бөгөөд Иудагийн омог м.э.ө. 10 - р зуунд эртний еврейн төрт ёс бүрэлдэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Анхандаа Иудагийн омгийн тэнгэр байсан Яхве тэнгэр төр улсын хэмжээнд шүтэгдэх болж, хожмоо ертөнцийн дээр оршигч нэгдмэл эзэн тэнгэрийн тай тахилга болж хувирчээ. Еврейн ард түмний олон зууны туршид төлөвшиж ирсэн сүсэг бишрэл Моисейн таван ном буюу Тора-д м.э.ө. 444 оны үед бичмэл хэлбэрээ олжээ. Иудаизмийн түүхэн хөгжлийн өөр, "Библийн" гэх үе м.э.ө. II зуунд тогтсон ба энэ үед иудейн шашны ариун судар Библи бүрэлджээ. Тэрхүү Библи судар нь христос шашинд Хуучин Гэрээ хэмээн нэрлэгдэх болсон. / 6, 1/

Хуучин Гэрээ. Хуучин Гэрээ нь Библийн эхний хэсэг бөгөөд еврейчүүд төдийгүй христос шашинтнууд Ариун судраа болгож шүтэж ирсэн. Библи гэдэг нь "ном судар" гэсэн грек үг бөгөөд еврейн хэлний "соферим" гэдгийн орчуулга. Энэ бол нэг зохиол бус, харин өөр өөр олон зохиолын цоморлиг. Уламжлал есоор Хуучин Гэрээг гурван том бүлэгт хуваадаг тухай С.А.Токаревийн өгүүлснийг үндэс болгон Хуучин Гэрээнд ордог зохиолуудыг Австралид хэвлэгдсэн англи хувилбарын холбогдох нэрийг хавсарган авч үзвэл:

1/ Хууль ёсны ном / еврей хэлээр **Тора** / буюу Моисейн таван ном. Тэдгээрийг домогт лүндэн буулгагч Моисей эмхтгэсэн гэж үздэг. Үүнд:

1. Ахуй /оросоор "**Бытие**", англиар "**Genesis**" /

Энд Эзэн тэнгэр / Ертөнцийн эзэн / ертөнц ба хүнийг бүтээсэн тухай, анхны хүн Адам, Ева хоёр диваажинд амьдарч байсан тухай, тэд нүгэл хийж, диваажингаас хөөгдсөн тухай, хүн төрөлхтөн өсөж үржсэн тухай, түүний нэн эртний түүхийн тухай, даян дэлхийн үер болж, Ной ба түүний гэр бүл аврагдсан тухай, еврей ард түмний өвөг дээдэс Авраам, Исаак, Иаков, Иосиф ба түүний ах дүү нарын тухай, еврейчүүд Египетэд нутагласан тухай.

2. Орхин одсон нь / оросоор **Исход**, англиар **Exodus** /

Энд еврейчүүдийн хууль тогтоогч Моисейн амьдрал, үйл ажиллагаа, еврейчүүд Египетээс суллагдсан тухай байхаас гадна декалог буюу Эзэн тэнгэрийн алдарт 10 сургаал болон шашны бусад дүрэм ёс байдаг.

3 Левит / **Leviticus** /

Энд мөн л шашны хууль ёс гол агуулга нь болдог.

4. Тооллого / **Numbers** /

Энд еврейчүүдийн хууль ёс, Египетээс одож, Палестиныг / "Ханаан нутаг" / эзлэх хүртэлх еврейчүүдийн түүхийг өгүүлнэ.

5. **Дэд хууль** /оросоор "**Второзаконие**", англиар **Deuteronomy** /

Энд мөн л шашны хууль ёсыг өгүүлнэ.

Моисейн таван номын дараа **Иисүс Навины ном** / **Joshua** / байх ба түүнд Иисүс Навины удирдлага дор еврейчүүд "Ханаан нутгийг" эзэлсэн тухай өгүүлдэг.

2/. **Зохиолууд** /оросоор "Писания"/

Энэ хэсэг нь түүхэн зохиолуудаас бүрдэх ба үүнд **Шүүгчдийн ном** /оросоор **Книга Судей**, англиар **Judges** /, **Руфь** / **Ruth** /, **Хаант улсын дөрвөн ном** / **Книги Царств** / гэгдэх **Самуилын хоёр ном** ба **Хаадын хоёр ном**, **Паралипоменоны** / **Хроники**, **Chronicles** / **хоёр ном** хэмээх угийн бичиг, товчоо, ойллого зохиолууд, **Ездра** / **Ezra** /, **Неемия** / **Nehemiah** / нарын ном, **Есфирь** буюу **Эсфирь** / **Esther** /, **Иова** / **Job** /. Мөн түүнчлэн **Псалтырь** хэмээх **Давид хааны бичсэн гэх шашны сүлд дууллын ном** / **Псалмы**, **Psalms** /, **Соломон хааны үлгэрийн ном** / **Притчи**, **Proverbs** /, **Екклесиаст** / **Ecclesiastes** /, **Дууллын Дуу** буюу **Соломоны гэгдэх дуолууд** / **Песнь Песней**, **Song of Songs** /.

3/. **Лүндэн буулгасан ном зохиол** / **Пророческие книги** /

Исаия / **Isaiah** /, **Иеремия** / **Jeremiah** /, **Иезекииль** / **Ezekiel** /, **Даниил** / **Daniel** / нарын номоос гадна 12 "бага лүндэн буулгагчдын" ном.

Англи Хувилбарт С.А.Токаревийн дурдаагүй "**Lamentations**" хэмээх Иерусалим хот м.э.ө. 586 онд сүйдсэнд харууссан 5 дуу орсон байна. / 6,7 /

Эдгээр бүх номыг бүхэлд нь христос шашинтнууд Хуучин Гэрээ хэмээн еврейчүүдийн хүлээн зөвшөөрдөггүй христос шашны Шинэ Гэрээнээс ялгаж нэрлэдэг ба гарал үүслийг нь өнөө хүртэл бүрэн тогтоогоогүй байдаг байна. / 6 /

С.А.Токаревийн өгүүлснээр, Библи судлал Европын орнуудад хөрөнгөтний хувьсгал, соён гэгээрлийн үед эхэлсэн. Христос шашны үзэл суртлаас хараат бус санаа оноо дэвшүүлсэн анхны сэтгэгчдийн дотор Т.Гоббс, Б.Спиноза нар байсан ба тэд Моисейг бичсэн гэж сүм хийдээс үзэж ирсэн номуудыг хожмын үед бичигдсэн болохыг ажиглажээ. Мөн Жан Астрик Библи судлалд чухал хувь нэмэр оруулжээ. Тэрээр "Ахуйн" номын эх сурвалж нь хоёр бие даасан зохиол байсан тухай таамаглал дэвшүүлсэн байна / 6 /. Сүм хийдийн бус судалгаагаар Хуучин Гэрээнд орсон зохиолууд бичигдсэн цаг хугацааны хувьд ч өөр өөр үед хамаарах ажээ.

Хуучин Гэрээнд 39 баталгаажуулсан буюу канон-д орсон / 4,1 / ном багтан ордог ба м.э.ө. IX зуунаас м.э. II зууны 60 - аадоны хооронд эртний еврей хэлээр, зарим нь арамей хэлээр бичигджээ. М.э.ө. сүүлчийн 2 зуунд грек хэлэнд орчуулагдаж Септуагинта хэмээх латин хэлний 70 гэсэн үгээр нэрлэгдэх болсон нь 72 хоногт орчуулагдсан гэх домогтой холбоотой. Үнэн хэрэгтээ бол Библи нь 2 зууны турш аажмаар орчуулагдсан байдаг байна. Септуагинтын 10 орчим зохиол, бусад зарим хэсэг хожмоо эртний еврей текстэд байхаа больж, ~~өнөөгийн иудейн шашны канонд орхоо больжээ.~~ Христос шашинд эдгээр нь мөн л канонд ордоггүй боловч католик ба үнэн алдрын шашны Библид Септуагинтагаас орчуулагдаж хэвлэгддэг байна.

Христос шашинд Септуагинта-г эртний еврей хэлээр бичигдсэн Хуучин Гэрээний нэгэн адил Эзэн тэнгэрийн бошго хэмээн үзэх аж.

IV зууны эцэс V зууны эхэнд гэгээн Иероним Хуучин Гэрээг латин хэлэнд орчуулагдаж Вульгата буюу нийтэд ойлгомжтой, ард түмний гэсэн нэрээр нэрлэгдэх болжээ. Энэ орчуулгыг католик шашин сүм хийдийн Тридентийн чуулган дээр /1545 -1563 /мөн Эзэн тэнгэрийн бошго хэмээн хүлээн зөвшөөрчээ.

Хуучин Гэрээг албан ёсны болгон баталгаажуулах үйл ажиллагаа м.э.ө. V зуунд эхэлж м.э. I зуунд Ямнийн раввины чуулган дээр дуусгавар болсон.

Христос шашин Хуучин Гэрээг иудаизмийн хэлбэршүүлсэн тэр байдлаар нь уламжилж авсан. Хэдэн зууны туршид Хуучин Гэрээг масоретууд редакторлаж хэлбэршүүлсэн байна.

Хуучин Гэрээний баталгаажуулж албан ёсны болгосон / канон - д орсон / ном зохиолоос гадна апокриф буюу нууц зохиолууд бас байдаг. / 1 /

Библийн ном зохиолоос гадна эртний еврей шашныг судлах цөөн эх сурвалж байдгийн дотор еврей түүхч Иосиф Флавийн 2 зохиол ба Хирбет-Кумраны суурингийн балгасны дэргэдэх олдвор байх ба еврей шашин төдийгүй анхан үеийн христос шашныг судлах чухал эх сурвалжийн тоонд ордог / 6 /. Эдгээрийн талаар дэлгэрүүлэн өгүүлбэл:

1. "Иудейн дайн" / "Иудейская война" / зохиолоо Иосиф Флавий 66-70 оныд болсон бослогын үйл явдлын талаархи хувийн ажиглалтандаа тулгуурлан бичжээ.
2. "Иудейн эрт цагийн юмс" / "Иудейские древности" / зохиолыг бол Библийн /Хуучин Гэрээ/ зохиолуудын үндсэн дээр бичсэн боловч аман яриа, домог хууч үгийг оруулсан онцлогтой байдаг байна.
3. Хирбет-Кумраны олдворын тухайд бол 1947-1957 онуудад Палестин, Үхлийн тэнгисийн эрэг дээр хи суурингийн балгаснаас м.э.ө. II - I зуунд хамаарах хуйлсан бичгүүд олдсон ба тэдгээрт батлагдсан /канон-д орсон/ эх сурвалжаас өөр Библийн бүрэлдэхүүнд орох ном зохиолын хувилбар хэсгүүд, даяанчдын нийгэмлэгийн дүрэм зэрэг байжээ. Тэр даяанчид нь эссенүүд байсан гэж үздэг.

Талмуд. Библи / Хуучин Гэрээ / - эс гадна еврейчүүд тусгаар тогтнолоо алдаж Газрын дундад тэнгисийн улс орнуудаар тарж бутарж дундад зууны еврейчүүд раввинуудаар толгойлуулсан хаалттай нийгэмлэг болж төлөвшиж байх үеийн иудаизмийн ном зохиолын цоморлиг бол III-V зууны хооронд бичигдсэн Талмуд бөгөөд Тора - г тайлбарлах үндсэн дээр бичигджээ. Түүнд шашин - эрх зүйн болон зан үйлийн хэм хэмжээнүүд багтан орж гүйцэтгэвэл зохих 248 зүйл ба 365 хориг цээр тусгалаа олсон байна.

Талмуд нь II-V зуунд бичигдсэн гэх боловч аман уламжлал нь хавьгүй эрт үед, м.э.ө. соферим буюу номчдын үйл ажиллагаатай холбоотойгоор тогтжээ. Тэд анх м.э.ө. III зуунд Египетэд, хожмоо бусад орнуудад бий болсон синагогуудыг толгойлж байсан ба Тора - г тайлбарлах үйл ажиллагааг эхлүүлж тэр тайлбарууд нь "Мишна" буюу Дэд хууль нэртэй болсон байна. Эдгээр тайлбарыг эмхтгэсэн хүн нь Иегуда Ганаси байжээ.

Хожмоо Мишна - гийн өөрийнх нь тайлбар Гемара бий болсон байна.

Харин Мишна, Гемара хоёр нийлээд Талмудыг бүдүүлсэн байна.

Талмудын хоёр хувилбар байх ба тэр нь Вавилонд эмхтгэгдсэн Талмуд Бавли ба Палестинд эмхтгэгдсэн Талмуд Иерушалми ба Вавилоныхыг илүүд үздэг аж. / 1 /

Талмуд хэмээн схоластик шинжтэй номчирхлыг нэрлэх болсон нь алхам бүрийг журамлах болсонтой нь холбоотой бололтой юм.

Яхвегийн хууль.

1. Яхве - гаас өөр тэнгэрийг шүтэхгүй байх.
2. Онгодыг шүтэхгүй байх.
3. Эзэн тэнгэрийн нэрийг хий хоосон дурдахгүй байх.

4. Хагас сайн өдрийг хүндэлж, бүх ажлаа орхин, Эзэн тэнгэрт энэ өдрийг зориулж байх.
5. Эцэг эхээ хүндэтгэж байх.
6. Хүний амь таслахгүй байх.
7. Буруу хурьцал үл үйлдэх.
8. Өгөөгүйг үл авах.
9. Худлаар гэрчлэхгүй байх.
10. Бусдын эд юмсыг хүсэхгүй байх.

Эдгээр хуулийг эзэн тэнгэр Моисейд Синайн уулан дээр дамжуулж өгсөн ба хоёр чулуун хавтан дээр бичигдсэн байсан гэдэг / 6,7 /.

Декалог буюу Эзэн тэнгэрийн дээрхи 10 хууль нь эртний еврейчүүдийн зан байдлын хэм хэмжээг илэрхийлэх бөгөөд Таван номонд багтан ордог. Гэхдээ эдгээрийг Моисейд дамжуулж өгсөн түүх болон хуулийн агуулга Таван номонд өөр өөр хувилбараар байдаг байна. Хэдий тийм боловч бүгдэнд нь зан үйл, зан байдлын дүрэм журам голлодог, тухайлбал бусдын тэнгэрүүдийг шүтэхгүй байх, тахилын эд зүйлсийг нь сүйтгэж байх, онгодыг бүтээж шүтэхгүй байх, өөр шашинтантай гэр бүл болохгүй байх гэх мэт / 1 /

Библи, түүний дотор Хуучин Гэрээний заалт христос шашинтнуудад нэн адил хамаарах боловч Шинэ Гэрээнд Хуучин Гэрээний зарим ёс үгүйсгэгдсэн байдаг байна.

Ном зохиол.

1. Атеистический словарь. М., 1986.
2. Кулаков А.Е. Религии мира. М., 1996.
3. Мюллер В.К. Англо - русский словарь. М., 1986.
4. Свенцицкая И.С. Тайные писания первых христиан. М., 1980.
5. Советский энциклопедический словарь. М., 1977.
6. Токарев С.А. Религия в истории народов мира. М., 1986.
7. Good News Bible. Australia, 1988.

Summary.

Hebrews' religion exerted great influence on Christianity and Islam, and the Holy scripture of Jewish people Bible / The Old Testament / is as well as worshipped by Christians. Here are considered the main sources of ancient Jewish religion with its ideas of God, creator of the universe.